



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/107/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Ц.Хосжаргал  
Утас: 261885 Цахим хаяг: [khosjargalts@audit.gov.mn](mailto:khosjargalts@audit.gov.mn)  
Аудитор: Э.Бүгүнэтэй  
Утас: 260512 Цахим хаяг: [bugunuteie@audit.gov.mn](mailto:bugunuteie@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Шинэ их тэрбум аудит" ХХК  
Захирал: Ц.Мишигдорж  
Цахим хаяг: [ikhterbum@gmail.com](mailto:ikhterbum@gmail.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	7
3. Аудитын тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	8
3.2 Дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	9
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	9
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
8. Аудитын илрүүлэлт .....	14
8.1 Залруулсан алдаа .....	15
8.2 Төлбөрийн акт .....	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	186

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН  
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Т.ЖАРГАЛСАЙХАН  
ТАНАА

2022.03.15 № 07/564  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хараат бус аудиторын тайлан

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Өмнөговь аймгийн татварын хэлтсээс 2017-2020 оны албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хийсэн хяналт шалгалтаар нийт 135.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон. Үүнээс 10.7 сая төгрөгийн зөрчлийг хүлээн зөвшөөрч, 124.4 сая төгрөгийн төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй талаар Татварын маргаан таслах зөвлөлд хандсан боловч нөхөн ногдуулалтын актыг хэвээр үлдээсэн шийдвэр гарсан байна. Хүлээн зөвшөөрөөгүй нөхөн төлбөрийн 10.0 хувийг төлж, 115.5 сая төгрөгийн болзошгүй өр төлбөрийн талаар захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргасан байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/21 дүгээр тушаалаар Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 23,458.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 23,478.7 сая төгрөгөөр, үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 638.9 сая төгрөгийг, алдагдлыг 20.3 сая төгрөг байхаар баталсан байна.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/154 дүгээр тушаалаар хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 689.7 сая төгрөг байхаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 23,326.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 23,059.2 сая төгрөгийн зардал гарган, 231.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компани нь 2021 оны 10 зорилтын хүрээнд холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэл 100.0 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

1	ХӨРӨНГӨ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	651,884,371.30	392,232,169.69
1.1.2	Дансны авлага	663,484,699.46	1,662,913,774.52
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	79,589,694.97	228,319,970.83
1.1.6	Бараа материал	194,493,366.75	109,831,048.71
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	7,473,913.78	6,538,637.84
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	52,107,681.78	52,107,681.78
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,649,033,728.04</b>	<b>2,451,943,283.37</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	16,647,401,941.98	16,680,990,635.26
1.2.2	Биет бус хөрөнгө	842,320,134.40	835,639,616.33
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>17,489,722,076.38</b>	<b>17,516,630,251.59</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,138,755,804.42</b>	<b>19,968,573,534.96</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	3,981,440.00	11,545,113.88
2.1.1.3	Татварын өр	0.00	19,144,748.16
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	54,562,719.56	43,644,466.20
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	46,522,174.00	28,869,139.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>105,066,333.56</b>	<b>103,203,467.24</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	454,480,000.00	414,960,000.00
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>454,480,000.00</b>	<b>414,960,000.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>559,546,333.56</b>	<b>518,163,467.24</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	16,845,740,900.16	16,845,740,900.16
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	621,749,200.00	681,771,461.65
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	881,049,485.25	1,176,368,559.25
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	230,669,885.45	746,529,146.67
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>18,579,209,470.86</b>	<b>19,450,410,067.73</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>19,138,755,804.42</b>	<b>19,968,573,534.96</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мерийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	23,480,677,450.20	23,081,328,011.48
2	Борлуулалтын өртөг	21,578,146,022.16	21,080,426,992.54
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>1,902,531,428.04</b>	<b>2,000,901,018.94</b>
5	Хүүний орлого	44,146,593.23	838,807.78
8	Бусад орлого	386,316,545.95	243,849,257.85

**Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

9	Борлуулалт, маркетингийн зардал	10,383,944.55	14,385,850.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,683,000,132.39	1,737,968,373.15
12	Бусад зардал	623,730,733.41	226,438,604.73
17	Бусад ашиг (алдагдал)	(8,543,653.40)	
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>7,336,103.49</b>	<b>266,796,256.69</b>
19	Орлогын татварын зардал	46,387,670.35	35,461,995.47
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(39,051,566.86)</b>	<b>231,334,261.22</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(39,051,566.86)</b>	<b>231,334,261.22</b>

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>15,602,307,128.05</b>	<b>621,749,200.00</b>	<b>2,117,681,257.36</b>	<b>269,721,452.31</b>	<b>18,611,459,037.72</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>15,602,307,128.05</b>	<b>621,749,200.00</b>	<b>2,117,681,257.36</b>	<b>269,721,452.31</b>	<b>18,611,459,037.72</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(39,051,566.86)	(39,051,566.86)
Өмчид гарсан өөрчлөлт	1,243,433,772.11		(1,236,631,772.11)		6,802,000.00
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>16,845,740,900.16</b>	<b>621,749,200.00</b>	<b>881,049,485.25</b>	<b>230,669,885.45</b>	<b>18,579,209,470.86</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				284,525,000.00	284,525,000.00
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>16,845,740,900.16</b>	<b>621,749,200.00</b>	<b>881,049,485.25</b>	<b>515,194,885.45</b>	<b>18,863,734,470.86</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				231,334,261.22	231,334,261.22
Өмчид гарсан өөрчлөлт			295,319,074.00		295,319,074.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		60,022,261.66			60,022,261.66
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>16,845,740,900.16</b>	<b>681,771,461.66</b>	<b>1,176,368,559.25</b>	<b>746,529,146.66</b>	<b>19,450,410,067.73</b>



Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	21,897,559,145.21	20,527,495,759.46
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	21,473,147,169.64	11,691,165,130.13
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,316,804.24	
	Буцаан авсан албан татвар	89,000,000.00	
	Бусад мөнгөн орлого	334,095,171.33	8,836,330,629.33
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	21,445,522,541.92	20,394,571,331.67
	Ажиллагчдад төлсөн	2,365,152,108.85	2,073,043,024.18
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	565,730,000.00	608,250,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	16,932,546,930.01	16,007,590,869.70
	Ашиглалтын зардалд төлсөн	11,536,166.91	4,726,011.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	47,437,919.18	62,169,766.82
	Хүүний төлбөрт төлсөн	4,841,200.00	4,544,800.00
	Татварын байгууллагад төлсөн	713,566,987.81	837,980,363.49
	Даатгалын төлбөрт төлсөн	6,561,245.00	13,677,371.00
	Бусад мөнгөн зарлага	798,149,984.16	782,589,125.47
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>452,036,603.29</b>	<b>132,924,427.79</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	44,729,893.23	3,229,214.78
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	583,300.00	2,390,407.00
	Хүлээн авсан хүүний орлого	44,146,593.23	838,807.78
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	608,518,058.82	356,285,844.18
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	608,518,058.82	356,252,238.18
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	33,606.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(563,788,165.59)</b>	<b>(353,056,629.40)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	39,520,000.00	39,520,000.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	39,520,000.00	39,520,000.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(39,520,000.00)</b>	<b>(39,520,000.00)</b>
<b>4.1</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>4.2</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(151,271,562.30)</b>	<b>(259,652,201.61)</b>
<b>5.1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>803,155,933.60</b>	<b>651,884,371.30</b>
<b>5.2</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>651,884,371.30</b>	<b>392,232,169.69</b>

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Худалдаж авсан цахилгаан	сая кВт.ц	110.2	110.2	106.1	4.1	96.3%
2	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал: хувиар	хувь	7.0	11.0	2.1	8.9	19.1%
	биетээр	сая кВт.ц	7.7	12.1	2.2	9.9	18.2%
3	Борлуулах цахилгаан эрчим хүч	сая кВт.ц	102.5	98.1	103.9	(5.8)	105.9%
4	<b>Нийт орлого</b>	<b>сая төг</b>	<b>23,911.1</b>	<b>23,458.7</b>	<b>23,326.1</b>	<b>132.6</b>	<b>99.4%</b>
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая төг	19,518.8	19,378.7	18,994.4	384.3	98.0%
	Түгээх үйлчилгээний төлбөр	сая төг	3,961.8	3,824.4	4,087.0	(262.6)	106.9%
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	430.5	255.6	244.7	10.9	95.7%
5	<b>Нийт зардал</b>	<b>сая төг</b>	<b>23,903.7</b>	<b>23,478.6</b>	<b>23,059.2</b>	<b>419.4</b>	<b>98.2%</b>
	Үүнээс: Үйл ажиллагааны зардал	сая төг	4,658.8	4,325.0	4,427.0	(102.0)	102.4%
	Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг	сая төг	19,091.7	18,953.5	18,519.5	434.0	97.7%
	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	153.2	200.1	112.7	87.4	56.3%
6	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/</b>	<b>сая төг</b>	<b>7.3</b>	<b>(20.0)</b>	<b>266.8</b>	<b>(286.8)</b>	<b>1334.0%</b>
	Цэвэр ашиг /алдагдал/	сая төг	(39.0)	(20.0)	231.3	(251.3)	1156.5%
7	Төрийн өмчийн ногдол ашиг	сая төг	-	-	-	-	-
8	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	1.0	1.0	1.0	0.0	99.0%
9	<b>Нийт авлага</b>	<b>сая төг</b>	<b>743.0</b>	<b>343.0</b>	<b>1,891.3</b>	<b>(1,548.3)</b>	<b>551.4%</b>
	Үүнээс: Цахилгааны авлага	сая төг	525.4	254.5	1,278.2	(1,023.7)	502.2%
	Бусад авлага	сая төг	217.7	88.5	613.1	(524.6)	692.8%
10	<b>Нийт өр төлбөр</b>	<b>сая төг</b>	<b>559.5</b>	<b>493.3</b>	<b>518.2</b>	<b>(24.9)</b>	<b>105.0%</b>
	Үүнээс: Богино хугацаат өглөг	сая төг	105.1	78.3	415.0	(336.7)	530.0%
	Урт хугацаат өр төлбөр	сая төг	454.5	415.0	103.2	311.8	24.9%
11	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая төг	686.3	638.9	638.5	0.4	99.9%
12	Нийт ажиллагсдын тоо	хүн	96	103	100	3	97.1%
13	Нийт цалингийн сан	сая төг	2,077.2	2,318.2	2,146.3	171.9	92.6%
	Нэг ажилтны дундаж цалин хөлс	сая төг	1.8	1.9	1.8	0.1	95.7%



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны мэдээллийг иж бүрэн мэдээлэх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-аас 03 дугаар сарын 15-ны хооронд Шинэ их тэрбум аудит ХХК-ийн аудитор Д.Дашдулам, Т.Энхтайван, аудиторын туслах М.Оюунтуяа нар гүйцэтгэж, хяналтыг захирал Ц.Мишигдорж хэрэгжүүлсэн.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/74 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тайлант онд тус байгууллагын цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах, цахилгаан импортлох тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагын хэрэгжилт, эрчим хүч хэмнэлтийн бодлогын хэрэгжилт, компанийн техник, санхүү, хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд Эрчим хүчний яамны удирдамжийн дагуу Эрчим хүчний зохицуулах хорооноос хяналт шалгалт хийж, техник хэрэгжилтийн талаар 8 зөрчил илэрч, 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр албан шаардлага хүргүүлсэн байна.

Тус компанийн гүйцэтгэх захирлын 2019 оны А/02 тоот тушаалаар батлан мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд компанийн дотоод аудитор нь төлөвлөгөөт 31 ажил, төлөвлөгөөт бус 4 ажлыг гүйцэтгэж, 9 тайлан гаргаж, засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтыг сайжруулах чиглэлээр 9 зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудиторын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 31 ажлаас компанийн 2021 оны зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 23,911.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 239.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

---

### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн зорилго нь цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд компанийн эзэмшлийн түгээх сүлжээ, шугам тоноглолын ашиглалт, засвар үйлчилгээ, өргөтгөл, шинэчлэлтийн ажлуудыг чанартай гүйцэтгэж, хэрэглэгчийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг хангах, цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд алдагдалгүй борлуулж, борлуулалтын орлогыг бүрэн цуглуулах, хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хангасан түвшинд зохион байгуулахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг цахилгаан эрчим хүч худалдаж авах, худалдах, импортлох, түгээх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай, өмчийн 100.0 хувийг төр эзэмшдэг, үүнээс ТӨБЗГ 30.0 хувь, Эрчим хүчний яам 70.0 хувийг эзэмшиж байна.

### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь ЗГ-ын 2013 оны 3 дугаар тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй, 9 дүгээр зүйлийн 5 хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит

хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сарын цалин, урамшууллыг нэг хүний 0.7 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10 “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Эрчим хүчний яамнаас зохион байгуулсан төрийн өмчит компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтад ТУЗ-ийн зөвлөлийн гишүүд, гол удирдах ажилчид хамрагдаж, гэрчилгээ авсан, төрийн өмчийн бүртгэл хөтлөлт, зах зээлийн үнэлгээг шинэчлэн тогтоох чиглэлээр компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгүүдийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулж үр дүнг санхүүгийн тайланд бүртгэсэн.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 3 нэгжээр бууруулсан, удирдлагын цалин хөлсийг ТУЗ-ийн 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 05/2021 дүгээр тогтоол, эдийн засгийн зорилтот түвшний орлого, үр ашигтай нь уялдуулан үндэслэлтэй тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамтын хэлэлцээр;
- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай 211 дүгээр тогтоол;
- Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 207 дугаар тогтоол;
- Эрчим хүчний сайдын 2021 оны А/53 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан эрчим хүчний импортлох болон экспортлох хэмжээг тогтоох тухай”
- Эрчим хүчний сайдын 2021 оны А/97 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний салбарын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тушаал, шийдвэр болон бусад баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”

#### **4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	651,884.4	392,232.2	(259,652.2)
Авлага	743,074.4	1,891,233.7	1,148,159.4
Урьдчилгаа	7,473.9	6,538.6	(935.3)
Бараа материал	194,493.4	109,831.0	(84,662.3)
Бусад эргэлтийн хөрөнгө	52,107.7	52,107.7	-
Үндсэн хөрөнгө	16,647,401.9	16,680,990.6	33,588.7
Биет бус хөрөнгө	842,320.1	835,639.6	(6,680.5)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>19,138,755.8</b>	<b>19,968,573.5</b>	<b>829,817.7</b>
Богино хугацаат өглөг	105,066.3	103,203.5	(1,862.9)
Урт хугацаат өглөг	454,480.0	414,960.0	(39,520.0)
Эздийн өмч	18,579,209.5	19,450,410.1	871,200.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>19,138,755.8</b>	<b>19,968,573.5</b>	<b>829,817.7</b>

Касс дахь бэлэн мөнгө 1.2 сая төгрөг, банк дахь харилцах дансанд 391.0 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд ААНОАТ-ын авлага 154.4 сая төгрөг, НӨАТ-ын авлага 73.9 сая төгрөг, НДШ-ийн авлага 0.3 сая төгрөг байна.

Тайлант онд Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын хүрээнд айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлбөрийг тэр хариуцсантай холбоотой төрөөс авах авлага 517.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 1,562.3 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 328.9 сая төгрөгийн шүүхийн шийдвэртэй авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулсан, найдваргүй авлагын хасагдуулгыг шууд аргаар тооцдог ба найдваргүй болж данснаас хассан авлага байхгүй байна.

Урьдчилгаа дансанд тайлант онд худалдан авах төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажил, урсгал засвар, сургалт, сэлбэг материалын үнэ, түрээс, вэб хостингийн 994.4 сая төгрөгийн урьдчилгааг бүртгэсэн байна.

Урьдчилгаа данснаас ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 995.4 сая төгрөгийг үндсэн хөрөнгө, сэлбэг материал, урсгал засвар, холбогдох зардлын дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 109.8 сая төгрөг болж 84.7 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд бараа материал 300.8 сая төгрөгийн сэлбэг, 11.9 сая төгрөгийн багаж хэрэгсэл, 32.9 сая төгрөгийн хангамжийн материал, 5.4 сая төгрөгийн бичиг хэрэг, 46.0 сая төгрөгийн шатах тослох материал, 34.5 сая төгрөгийн тээврийн хэрэгслийн сэлбэг, 53.4 сая төгрөгийн хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авсан дүнгээр нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 52.1 сая төгрөгийн нөөцийн бараа материал нь гэнэтийн нөхцөл байдалд зайлшгүй бэлэн байлгах ёстой сэлбэг байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 560.4 сая, ТӨБЗГ-ын 2021 оны 506 дугаар тогтоолын дагуу хөрөнгийн дахин үнэлгээгээр 60.0 сая, ТӨБЗГ-ын 339 дүгээр тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтыг шилжүүлэн авсан 295.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/1811 дүгээр тогтоолоор акталсан 2.5 сая төгрөгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 6.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны хорогдлын зардлаас шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансанд аж ахуйн нэгж байгууллагад өгөх өглөг 11.5 сая төгрөг, төсөвт ажлын өглөг 28.9 сая төгрөг, татварын өр 19.1 сая төгрөг, урьдчилж орсон орлого 43.7 сая төгрөгийн өр төлбөрүүд байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 2018 онд үүссэн Эрчим хүчний төслийн дамжуулан зээлдүүлэх зээлийн өр төлбөрөөс 39.5 сая төгрөгийг барагдуулж, 415.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, эргэн төлөгдөх хуваарийн дагуу төлөгдөж байгаа зээлийн өглөг бүртгэлтэй байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт компанийн тайлант хугацаанд гарсан өртөг, зардлыг ашиглалт, засвар, үйлчилгээ, ерөнхий удирдлага, борлуулалт маркетинг гэсэн өртгийн төвүүдэд аккруэл сууриар бодитой, үнэн зөв тооцож, тайлант хугацаанд нь зохистой ангилж, хуваарилж бүртгэх, үйл ажиллагааны бусад зардлыг аккруэл сууриар зөв, тооцож бүртгэхээр заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий ба удирдлагын зардал, үйл ажиллагааны бус зардал ба гарз гэж ангилсан байна.

Борлуулалтын өртөг өмнөх онтой харьцуулахад 497.7 сая төгрөгөөр буурсан нь борлуулалтын орлого буурснаас шалтгаалсан байна.

Өмнөх оноос борлуулалт, маркетингийн зардал 4.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь маркетингийн зардлын өсөлтөөс, ерөнхий ба удирдлагын зардал 397.3 сая төгрөгөөр буурсан нь албан томилолт, ашиглалт, хангамжийн зардлууд буурснаас тус тус шалтгаалжээ.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт худалдаж авсан цахилгааны эрчим хүч, цахилгаан шугам сүлжээ, авто хэсэг, техник хангамжийн хэсгүүдийн ажилчдын цалин, ашиглалтын зардал, урсгал засвар, шатах тослох материал, тоног төхөөрөмжийн элэгдлийн зардал, хангамжийн материал, албан томилолт, баяр ёслол, шагнал урамшуулал, тэтгэмж тусламж, сургалт, эмчийн үзлэг зэрэг зардлыг хамруулсан байна. Үүнээс баяр ёслол, шагнал урамшуулал, тэтгэмж тусламж, эмчийн үзлэг зэрэг материаллаг бус зардлууд нь өртөгт хуваарилагдахгүй зардлууд байна.

НБББББ-т “Цахилгаан эрчим хүч худалдан авч түгээх үндсэн үйл ажиллагаатай холбоотой бүтээгдэхүүний өртөгт эдгээр зардлуудыг оруулна” гэж заасан нь НББОУС-2 Бараа материалын стандарт 16-р параграф “*Бараа материалын өртөгт оруулдаггүй бөгөөд гарсан тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг зардлын жишээнд дараах зүйлс хамаарна. Үүнд: хаягдал материал, хөдөлмөр буюу үйлдвэрлэлийн бусад зардлын хэвийн бус дүн, бараа материалыг одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдож гараагүй удирдлагын нэмэгдэл зардал*” гэсэн заалттай зөрчилдөж байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/21 дүгээр тушаалаар Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 23,458.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 23,478.7 сая төгрөгөөр, үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 638.9 сая төгрөг, алдагдлыг 20.3 сая төгрөгийн байхаар төлөвлөжээ.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/154 дүгээр тушаалаар хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 50.9 сая төгрөг байхаар нэмж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 23,326.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 23,059.2 сая төгрөгийн зардал гарган, 231.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 23,326.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 132.6 сая төгрөг буюу 0.6 хувиар тасарсан нь борлуулах дундаж үнэ буурсан, үйл ажиллагааны бус орлого буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 23,059.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 419.4 сая төгрөг буюу 1.8 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь худалдаж авах цахилгаан эрчим хүчний төлөвлөгөө 4.1 сая вКт.ц эрчим хүчээр тасарсан, орон тоо дутуу ажилласан зэрэг нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 21 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 638.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 231.3 сая төгрөг болж, алдагдлыг бууруулж ажилласан нь худалдаж авах цахилгаан эрчим хүчний төлөвлөгөө тасарснаас 434.0 сая төгрөгийн хэмнэлт, үйл ажиллагааны бус зардлыг 87.4 сая төгрөгөөр тус тус хэмнэснээс нөлөөлжээ.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнээс 75.3 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1.мэдээлэл



үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3. тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг ил тод, хугацаанд нь бүрэн байршуулах зөвлөмж өгөв.

## **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Компани нь 5.1 сая төгрөгийн шагнал, урамшууллын зардал гаргасан нь Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 *"Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүй байх;"* гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## **6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

---

Завсрын аудитаар 55.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 42.7 сая төгрөгийг залруулж, 12.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар үргэлжлүүлэн авч үзсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 113.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс 100 хувийн биелэлттэй байна.

## **7. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

---

Өмнөговь аймгийн татварын хэлтсээс 2017-2020 оны албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн 124.4 сая төгрөгийн төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй талаар захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн талаар дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **8. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 336.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 327.2 сая төгрөгийн алдааг залруулж, 9.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Залруулагдаагүй 9.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 239.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Зөрчилгүй" дүгнэлт өглөө.



### 8.1 Залруулсан алдаа

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 327.2 сая төгрөгийн орон сууцны хөнгөлөлтийн ажилчдаас авах авлагыг бүртгэснийг залруулсан.

### 8.2 Төлбөрийн акт

ТУЗ-ийн гишүүдэд жилийн үр дүнгийн шагналд 9.2 сая төгрөгийг үндэслэлгүй олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12. "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно.", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.", гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Дээрх 5.1-д өгсөн зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/																
д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар</b>																
1	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	АХГ-2022/107/НА-СТА-ТӨА	327.2 сая төгрөгийн орон сууцны хөнгөлөлтийн ажилчдаас авах авлагыг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт оруулж бүртгэсэн.	Ажилчдаас авах авлагаар бүртгэж залруулсан.	1	327,219.4	1	327,219.4								
2	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	АХГ-2022/107/НА-СТА-ТӨА	ТУЗ-ийн гишүүдэд жилийн үрдүнгийн шагналд 9.2 сая төгрөгийг үндэслэлгүй олгосон.	Төлбөрийн акт тогтоосон.	1	9,152.2			1	9,152.2						
<b>ДҮН</b>					<b>2</b>	<b>336,371.6</b>	<b>1</b>	<b>327,219.4</b>	<b>1</b>	<b>9,152.2</b>						
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал</b>																
3	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	АХГ-2022/107/НА-СТА-ТӨА	Шилэн дансанд 75.3 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан.	Шилэн дансны мэдээллийг иж бүрэн мэдээлэх талаар зөвлөмж өгсөн.	1	75.342.9									1	75.342.9
4	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	АХГ-2022/107/НА-СТА-ТӨА	5.1 сая төгрөгийн шагнал урамшууллын зардал гаргаж, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.	Албан шаардлага хүргүүлсэн.	1	5,055.0					1	5,055.0				
<b>ДҮН</b>					<b>2</b>	<b>80,397.9</b>					<b>1</b>	<b>5,055.0</b>			<b>1</b>	<b>75.342.9</b>
<b>НИЙТ ДҮН</b>					<b>4</b>	<b>416,769.5</b>	<b>1</b>	<b>327,219.4</b>	<b>1</b>	<b>9,152.2</b>	<b>1</b>	<b>5,055.0</b>			<b>1</b>	<b>75.342.9</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 407/А0150055  
АХГ-2022/107/НБ-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компани нь 5,055,000.00 төгрөгийн шагнал урамшууллын зардал гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."; Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Т.Жаргалсайхан, Төлөвлөлт, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч М.Өлзийнэмэх нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
Д.ДАШДУЛАМ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

№10.10.10.20/Bichig\_Khereg/Alban\_Shaardlaga/2022/0315\_Auditin\_2\_Gazar-77.Docx

0010801137



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 82/А0150055  
ААГ-2022/1107/НБ-СТБ-ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 8 гишүүнд жилийн үр дүнгийн шагнал 9,152,207.00 төгрөгийг үндэслэлгүй олгосон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12 "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно.", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгосон жилийн үр дүнгийн шагнал 9,152,207.00 /Есөн сая нэг зуун тавин хоёр мянга хоёр зуун долоо/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Т.Жаргалсайхан, Төлөвлөлт, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч М.Өлзийнэмэх нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
Д.ДАШДУЛАМ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2022\0315\_Auditin 2 Газар-16.Docx

001090231



